БАТЛАВ

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ

33БНбД 84-021-2016 "АВТО ЗАМ, ГҮҮРИЙН АРЧЛАЛТ, ЗАСВАРЫН АЖЛЫН ЗАРДЛЫН СУУРЬ НОРМ"-ЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 20 -ны өдөр № 2024/03-01 Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага:
   - "Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2024-2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө".
   - Авто зам, замын байгууламжид хийгдэх арчлалт, засварын ажлыг нормативаар санхүүжүүлснээр түүний эдийн засгийн үр өгөөжийг хадгалах замаар ирээдүйн хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэх юм.
   - Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд зарцуулах хөрөнгө хүрэлцээгүй авто зам, замын байгууламж тооцоот хугацаанаас өмнө эвдрэлд орох явдал хэвийн үзэгдэл болж, авто замын сүлжээнд нийт урт их хэмжээний эвдрэл, гэмтэл хуримтлагдаж авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдал хангагдахгүй болох эрсдэл үүсч байна.
2. Зөвлөх үйлчилгээний зорилго:
   - 2016 онд батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 33БНбД 84-021-2016 "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм"-ыг бусад холбогдох суурь норм, үнэ тарифын шинэчлэлтэд нийцүүлэн боловсруулж батлуулах.
3. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ:
   - Төслөөр *а) 33БНбД 84-021-2016 нормыг шинэчлэн боловсруулахдаа гүйцэтгэлээр болон норматив буюу бэлэн байдлын түвшинд суурилсан үнэлгээг тус тусад нь гарган өнөөгийн шаардлагад нийцүүлэх, салбарын байгууллага, ИТА-уудаас гаргасан санал, төсөл тооцоог нэгтгэн боловсруулах; б) Авто зам, замын байгууламжийн хийцийн төрөл, газар нутгийн төвөгшил, хот суурин байгалийн үзэгдэл /авто зам, гүүрийн ашиглалтын хугацаа, техникийн ангилал, хөдөлгөөний эрчим, зам цаг уурын бүсчлэлийн нөлөөлөл, алслагдсан зай, байгалийн хүчин зүйлсийн нөлөөллийг тооцсон итгэлцүүр тус бүрийг тооцсон/ зэрэг онцлогоор нь үнэ бүрдлийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив үндэслэн нормативуудыг тодорхойлж асуудлыг шийдсэн байна.*
4. Зөвлөх үйлчилгээний
   - 33БНбД 84-021-2016 "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм"-ыг шинэчлэх талаар 2016-2023 онд

хүрээнд гүйцэтгэх ажил, үүрэг:	гарсан холбогдох тооцоо судалгаа, зам цаг уур амьсгалын нөлөөллийг тооцсон байх. Үүнд: • *Байгалийн давагдашгүй хүчин зүйлс болох үер усны гамшиг мөн цас ихээр унаж хаагдаж боогдох үзэгдэл давтан гарч байгаа цэгийн судалгаа* • *Говь, хээрийн бүс нутагт элсний нүүдэл, авто зам, замын байгууламжид үзүүлж байгаа нөлөөлөл* • *Цэвдэгтэй бүс нутагт цэвдэг авто зам, замын байгууламжид үзүүлж байгаа нөлөөлөл* • *Авто зам, замын байгууламжийн ашиглалтын өнөөгийн түвшинд ROMDAS судалгааны тээврийн хэрэгслээр цуглуулсан өгөгдөл, үзүүлэлт* • *Авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцлийг хангах зорилгоор санхүүжилтийн норматив үнэлгээг тогтоохдоо Монгол оронтой байгаль цаг уурын хувьд ижил төстэй улсуудад баримталдаг зарчим, зам засварын байгууллагуудад түншлэн хийсэн судалгааг хийсэн байх.* • Норматив зардлыг жил бүр индексжүүлсэн засвар арчлалтын зардлын төлөвлөгөөг зам барилгын материал, тээвэр, машин ашиглалтын зардал, ажилчдын тарифт цалингийн өөрчлөлттэй уялдуулан гаргадаг байхаар боловсруулна. • Авто замын техникийн ангилал, хөдөлгөөний эрчим, төвлөрсөн нутгаас алслагдсан байдал зэргийг харгалзан үзсэн байх. • Нормативыг улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засвар /арчлалт, урсгал засвар ба ээлжит засвар/-т зарцуулах хөрөнгийг хуваарилах, төлөвлөхөд шууд хэрэглэх боломжтой байхаар боловсруулах. *Жич: Аймгийн төв болон суурийн газраас дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замын арчлалт, засварын норматив зардлыг хэрхэн тооцож нормд тусгах талаар.*
5. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд	• Монгол Улсын Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.6 дүгээр заалт
6. Зөвлөх үйлчилгээний баримт бичгийн бүрдэл:	• Төсөл нь а) Шинэчлэн боловсруулсан "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм"; б) Суурь нормативыг авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын нэр төрлөөс нь хамааруулан шаардагдах зардлын жишиг тооцоо /Асфальтбетон хучилт, Цементбетон хучилт, хайрган хучилт, хөнгөвчилсөн хучилт, сайжруулсан

		хөрсөн зам, төмөр бетон, модон гүүр гэх мэт/ гэсэн бүрдэл хэсгүүдтэй байна.
7.	Зөвлөх үйлчилгээний үр дүн:	• "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм"-ыг гүйцэтгэлийн болон бэлэн байдлын түвшинд суурилсан гэсэн 2 төрлөөр зааглан шинэчлэлтийг хийснээр, төсөв зохиох ажлын практикт шууд хэрэглэн төлөвлөлтөд хурдан ашиглан гарч болох онцлог, төвөгтэй ойлголтуудыг шийдсэн суурь норм болсон байна. • Уг нормыг мөрдүүлснээр авто зам, гүүрийн ашиглалтын нөхцөл сайжирч, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ.
8.	Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх байгууллага:	• "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий Зөвлөх баг болон хуулийн этгээд (Сонгон шалгаруулалтаар) байна.
9.	Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа:	• 10 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)
10.	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр:	• 42,000,000.0 төгрөг. • "Авто замын норм нормативын сан".
11.	Онцгой нөхцөл	• Сангийн яам болон Монголын Үндэсний Статистикийн Хорооны санал, шүүмжийг авч нягт уялдаа, холбоотой хамтарч ажиллах. • Авто замын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон бусад хууль, дүрэм журам, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй мөн шинээр болон шинэчлэн батлагдсан стандарт норм норматив, техникийн баримт бичгүүдтэй уялдуулах, нийцүүлэх. • Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг MNS 2492:2004 "Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага" стандартын дагуу боловсруулах. • Салбарын мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ сургалт судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, зөвлөх инженерүүдээс албан бичгээр санал авах, саналыг аргачлалын төсөлд хэрхэн тусгасан талаар саналын товчоо, тайлбар танилцуулга гаргах. • Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан 1-оос доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг Захиалагчийн болон мэргэжлийн холбоодын цахим хуудсаар дамжуулан мэдээллийг хүргүүлэн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд санал шүүмжийг тусгах.

- Нормын эцсийн төсөл (Редакц, шүүмжийн ажлын хэсгийн төслийн эцсийн тайланг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар эцсийн дүгнэлт гарсан байх)-ийг Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөл болон Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулах;
- Зөвлөмжийн дагуу шаардлагатай өөрчлөлт, боловсруулалтыг хийн, танилцуулгын хамт батлуулахаар Захиалагчид хүргүүлэх.
- Захиргааны ерөнхий хуулийн 61-р зүйлийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу батлагдсан аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, бүртгүүлэхэд Захиалагчтай хамтран ажиллах.
- Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрхийн тухай” хуулийн 19.1, 19.2, 19.5 дугаар зүйл, Оюуны өмчийн тухай хуулийн 7.2, 7.3 дахь зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн өмч болно.

ХЯНАСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Д.БАЗАРСАД

БОЛОВСРУУЛСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн — Г.АНХЦЭЦЭГ